



КИНО ТЕАТРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА



Кино театрын зах зээлийн ерөнхий мэдээлэл
Кино театрт кино үзэгсэд
Үзвэрийн орлого
Кино театрын зах зээлийн эзэмшил
Кино театрын зах зээлийн онцлог
Судалгааны гол дүгнэлт

9

УЛААНБААТАР ХОТЫН КИНО ТЕАТРЫН ТОО

6873

НИЙТ СУУДЛЫН ТОО

2015 онд хамгийн олон буюу 1428 суудал нэмэгдсэн бол
2018 онд 612 суудал нэмэгджээ.

43

НИЙТ ДЭЛГЭЦИЙН ТОО

2016 онд хамгийн олон буюу 8 дэлгэц нэмэгдсэн бол
2018 онд 6 суудал нэмэгджээ.

174

ӨДӨРТ ГАРЧ БУЙ ҮЗВЭРИЙН ТОО

40%

АЖЛЫН ӨДРҮҮДЭД СУУДАЛ ДҮҮРГЭЛТ

18:00 цагаас өмнөх

КИНО ТЕАТРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УБ хотод үйл ажиллагаагаа явуулж буй кино театрууд

2003 онд орчин үеийн шаардлагад нийцсэн “Тэнгис” кино театр нээгдэж, 2009 онд хуучны “Өргөө” кино театр шинэчлэгдэн байгуулагджээ. 2011 онд “Өргөө 2”, 2012 онд “Жонон”, 2013 онд “Соёмбо” кино театр үүдээ нээсэн бөгөөд томоохон их дэлгүүрүүдийг дагасан Хүннү, Гэгээнтэн кино театрууд 2015 онд нээлтээ хийсэн. 2016 онд Өргөө кинотеатрын 3 дахь салбар болох “IMAX” кино театр Шангри-Ла төвд, “iCinema” кино театр УИД-д тус тус нээгдсэн байна. Түүнчлэн хамгийн отгон 4D кинотеатр “Prime Cineplex” нь Зайсан хилл соёл амралтын цогцолборт үүд хаалгаа нээгээд байна.



2011 он хүртэл кино театрын тоо харьцангуй тогтвортой байсан бол сүүлийн жилүүдэд жилд 1-2 кино театр үүдээ нээж, улмаар 2014 онд Улаанбаатар хот 4 кино театрт байсан, 2018 онд байдлаар 9 кино театр үйл ажиллагаагаа явуулж байна.

Кино театр дэлгэцийн тоо

УБ хотод байгаа 9 кино театр нийтдээ 43 дэлгэцтэй бөгөөд 2010 оноос 2018 оны хооронд жилд дунджаар 4 дэлгэцээр нэмэгдэж байсан бол 2015 ба 2016 онд хамгийн олон буюу тус бүр 8 дэлгэцээр нэмэгдсэн байна.

Кино театрын суудлын тоо

Дээрх 9 кино театр нийтдээ 6873 суудалтай бөгөөд 2010 оноос 2018 оны хооронд жилд дунджаар 607 суудлаар, ялангуяа 2015 онд хамгийн олноор буюу 1428 суудлаар нэмэгджээ. Тодруулбал, 2015 онд Хүннү, Гэгээнтэн кино театрууд нээгдсэнээр нийт суудлын тоо 2014 оноос 50%-иар, 2016 онд Өргөө 3-IMAX, iCinema кино театрууд нээгдсэнээр нийт суудлын тоо 2015 оноос 32%-иар өссөн байна. Өөрөөр хэлбэл 2015 оноос хойш 5 кино театр шинээр нээгдсэн бөгөөд суудлын тоо 3403-аар өссөн байна.


Хугацааны динамикийн хувьд кино театрын зах зээлийг аваад үзэхэд 2015 оноос хойш 5 кинотеатр шинээр нээгдсэн бөгөөд үүний нэг нь Өргөө кино театрын салбар бол үлдсэн 4 нь энэ зах зээлд шинээр орж ирсэн тоглогчид ажээ. 2014 онтой харьцуулахад зах зээлийн багтаамж нийлүүлэлт талаасаа 2 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл кинотеатрын тоо 2.25 дахин, суудлын тоо 2.2 дахин, дэлгэцийн тоо 2.4 дахин өсжээ.



КИНО ТЕАТРТ КИНО ҮЗЭГСЭД

Идэвхитэй үзэгч буюу 18-65 насны хүмүүсийн дунд явуулсан судалгаагаар 18-35 насны үзэгчид нийт кино үзэгчдийн дийлэнх буюу 72%-ийг бүрдүүлж байгаа бол 35-55 насны үзэгчид 23%-ийг бүрдүүлж байна. Хүйсийн хувьд авч үзвэл 51%-ийг эрэгтэй, 49%-ийг эмэгтэй үзэгчид бүрдүүлдэг ажээ.

Кино үзэгсэд, насны бүлгээр



Кино үзэгсэд, хүйсээр




Кино үзэгсэд, сарын орлогоор



Кино театрт кино үзэгчдийн өрхийн сарын дундаж орлогын бүлэгт 1,000,001-1,500,000 төгрөгийн сарын орлоготой үзэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 36% байгаа бол 29% нь 500,001-1,000,000 төгрөг, 16% нь 500,000 төгрөг хүртэл, 11% нь 1,500,001-2,000,000 төгрөг, 8% нь 2,000,001 төгрөгөөс дээш өрхийн сарын орлоготой ажээ.

Кинотеатруудын сарын нийт үзэгчдийн тоо



Өргөө кино театрын нийт салбаруудаар сард хамгийн олон буюу 160,000 гаруй үзэгчид үйлчлүүлдэг ба энэ нь нийт кино театраар үйлчлүүлэгчдийн 37% юм. Дээрх кино театруудад ажлын өдөр дунджаар 15,081 үзэгч, амралтын өдөр дунджаар 22,633 үзэгч кино үздэг бөгөөд УБ хотод сардаа дунджаар 512,837 хүн кино үздэг гэсэн тойм тооцооллыг хийлээ. Тодруулбал нийлүүлэлт талаасаа зах зээлийн багтаамжийг тооцоход сард дунджаар 512,837 үзэгч УБ-т үйл ажиллагаагаа явуулж буй кино театруудад үйлчлүүлдэг ажээ. Хэрвээ кино театрууд бүрэн хүчин чадлаараа буюу үргэлж 100%-ийн дүүргэлттэй байдаг гэвэл потенциал үзэгчийн тоо өдөрт 3,233, сардаа 969,990 үзэгч байна. Өөрөөр хэлбэл дээрх тооцоогоор кино театрууд сардаа потенциал үзэгчдийнхээ 53%-ийг хүлээж авдаг байна.

Эрэлтийн талаас нь зах зээлийн багтаамжийг тоймлон авч үзье. Хэрэглэгчийн судалгаанд оролцсон 400 хүний 62% нь чөлөөт цагаараа кино үздэг, сардаа дунджаар нэг удаа кино үздэг гэж хариулсан байна. Тэгвэл УБ хотод 15-59 насны 888,470 иргэн амьдарч байгаа бөгөөд үүний 62% буюу 550,851 нь сардаа нэг удаа кино үздэг гэж үзэж болох юм. Кино театрын үзэгчдийн тоог эрэлт нийлүүлэлт талаас нь авч үзэхэд нэлээд ойролцоо тоо гарсан байна. Эрэлтийн талаас тооцсон үзэгчийн тоо нийлүүлэлтийн талаас тооцсон үзэгчийн тооноос 38,014 үзэгчээр илүү гарсан байна. Иймд дээрх үзэгчдийн тоог нэлээд бодитой тоо хэмээн дүгнэж байна.

ҮЗВЭРИЙН ОРЛОГО

Кино театрын зах зээл сарын нийт орлого

4.16 тэрбум төгрөг


Үүнээс:

183.7 Амралтын өдрүүдийн дундаж орлого **сая төгрөг**

122.5 Ажлын өдрүүдийн дундаж орлого **сая төгрөг**

Борлуулалтын орлогыг тооцохдоо үзэгчдийн тоог үзвэрийн үнээр үржүүлж тооцсон бөгөөд үзвэрийн үнэ гэдэгт зөвхөн том хүний энгийн үзвэрийн үнийг авч үзлээ.

Сарын үзвэрийн орлого, кино театруудаар /сая төгрөг/




Өргөө кино театр сардаа дунджаар 1.8 тэрбум төгрөг, Тэнгис сардаа дунджаар 938.2 сая төгрөг, Хүннү сардаа дунджаар 637.3 сая төгрөг, Гэгээнтэн сардаа дунджаар 401.5 сая төгрөг, iCinema сардаа дунджаар 203.89 сая төгрөг, Соёмбо сардаа дунджаар 139.5 сая төгрөгний орлоготой гэсэн тойм тооцоолол хийлээ

КИНО ТЕАТРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭЗЭМШИЛ

Үзэгчдийн тооны эзэмшлийн хувьд Өргөө нийт үзэгчдийн 37%-ийг, Тэнгис 27%-ийг, Хүннү 18%-ийг, Гэгээнтэн 8%-ийг, iCinema 5%-ийг, Соёмбо 4%-ийг тус тус эзэмшиж байна.


Зах зээлийн эзэмшил /үзэгчдийн тоогоор/



Өргөө кино театр сардаа дунджаар 1.8 тэрбум төгрөг, Тэнгис сардаа дунджаар 938.2 сая төгрөг, Хүннү сардаа дунджаар 637.3 сая төгрөг, Гэгээнтэн сардаа дунджаар 401.5 сая төгрөг, iCinema сардаа дунджаар 203.89 сая төгрөг, Соёмбо сардаа дунджаар 139.5 сая төгрөгний орлоготой гэсэн тойм тооцоолол хийлээ.

КИНО ТЕАТРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ОНЦЛОГ

Үзвэрийн тоо, кино театруудаар



18 цагаас өмнөх үзвэрийн тоог нийт үзвэрийн тоонд харьцуулахад эдгээр кино театрууд өдрийн үзвэрийнхээ дунджаар 59%-ийг 18 цагаас өмнө гаргаж байна. Тэнгис кино театр өдрийн нийт үзвэрийнхээ 51%-ийг, Өргөөгийн салбарууд өдрийн нийт үзвэрийнхээ 52%-55%-ийг 18 цагаас өмнө гаргаж байна. Өөрөөр хэлбэл эдгээр кино театрууд дүүргэлтийн хэмжээ ихэсдэг үеэр киногоо шахаж гаргадаг ажээ.

Ажил ба амралтын өдрүүдийн үзэгчдийн тоо

22713

Амралтын өдрүүдийн үзэгчдийн тоо

15140

Ажлын өдрүүдийн үзэгчдийн тоо

Ажлын өдрийн нийт үзэгчийн тоог (15140) амралтын өдрийн нийт үзэгчийн тоотой (22713) харьцуулахад 50%-иар илүү байна. Энэ нь кино театр бүрийн хувьд бараг адилхан буюу амралтын өдрийн үзэгчдийн тоо ажлын өдрийн үзэгчдийн тооноос 48%-60%-иар их байна

Ажлын өдрүүдийн үзвэр

5971

18:00 цагаас өмнө

7873

18:00 цагаас хойш

Өмнө авч үзсэнчлэн ажлын өдрийн үзэгчдийн тоог 18 цагаас өмнөх ба хойших гэж хуваан авч үзсэн. Дээрх 8 кино театрын хувьд ажлын өдрийн 18 цагаас өмнөх үзэгчдийн тоо 7207, 18 цагаас хойших үзэгчдийн тоо 7874 бөгөөд ажлын өдрийн нийт үзэгчдийн тоо 15,081 байна. Тодруулбал 18 цагаас хойших нийт үзэгчийн тоо 18 цагаас өмнөх нийт үзэгчийн тооноос 10%-иар их байна.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хугацааны динамикийн хувьд кино театрын зах зээлд 2015 оноос хойш 5 кино театр шинээр нээгдсэн бөгөөд үүний нэг нь Өргөө кино театрын салбар бол үлдсэн 4 нь энэ зах зээлд шинээр орж ирсэн тоглогчид ажээ. 2014 онтой харьцуулахад зах зээлийн багтаамж нийлүүлэлт талаасаа 2 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл кино театрын тоо **2.25** дахин, суудлын тоо **2.2** дахин, дэлгэцийн тоо **2.4** дахин өсжээ.

Нийлүүлэлт талаас нь тооцоход УБ хотод үйл ажиллагаагаа явуулж байгаа 8 кино театрт ажлын өдөрт дунджаар **15,081 үзэгч**, амралтын өдөр дунджаар **22,633 үзэгч** кино үздэг бөгөөд УБ хотод сардаа дунджаар **512,837 хүн кино үздэг** байна.

8 кино театрын потенциал үзэгчийн тоо өдөрт **32,333**, сардаа **969,990 байх боломжтой** бөгөөд кино театрууд сардаа потенциал үзэгчдийнхээ 53%-ийг хүлээн авч байна.

Эрэлтийн талаас нь тооцоход сард **550,851** хүн кино үздэг ажээ. Үүнийг нийлүүлэлт талаас нь тооцсон үзэгчдийн тоотой харьцуулахад нэлээд ойролцоо гарсан байна. Иймд үзэгчдийн тоог нэлээд бодитой тооцсон хэмээн дүгнэж байна.

8 кино театр нийлээд үзвэрээсээ ажлын өдөрт дунджаар **122.5 сая** төгрөг, амралтын өдөр дунджаар **183.7 сая** төгрөг, сардаа **4.16 тэрбум** төгрөгний орлоготой ажээ.

Кино театруудаас суудлын тоо, дэлгэцийн тоогоор Өргөө кино театр тэргүүлж, нийт зах зээлийн 1/3 гаруй хувийг эзэлж байна. Суудлын тооны хувьд Өргөөгийн дараа Тэнгис, Хүннү кинотеатрууд тэргүүлэх эгнээнд байгаа бол дэлгэцийн тооны хувьд Өргөөгийн дараа шинээр ашиглалтад орох Зайсан хиллийн кинотеатр, Тэнгис кинотеатрууд байна.

Кино театруудын нэг танхимд ноогдох дундаж үзвэрийн тоо 6 байна. Гэхдээ Тэнгис кино театр бусдаас хамгийн эрчимтэй ажиллаж байгаа бөгөөд нэг танхимд ноогдох үзвэрийн тоо нь 7.4 байна. Ингэснээрээ Тэнгис кино театр үзэгчдийнхээ тоог 20 орчим хувиар нэмэгдүүлж байна.

Кино театрууд өдрийн үзвэрийнхээ дунджаар 59%-ийг 18 цагаас өмнө гаргаж байна. Тэнгис кино театр өдрийн нийт үзвэрийнхээ 51%-ийг, Өргөөгийн салбарууд өдрийн нийт үзвэрийнхээ 52%-55%-ийг 18 цагаас өмнө гаргаж байна. Өөрөөр хэлбэл эдгээр кино театрууд дүүргэлтийн хэмжээ ихсдэг үеэр киногоо шахаж гаргадаг ажээ.

Нийт үзэгчдийн 37% нь Өргөөгийн салбаруудаар, 27% нь Тэнгисээр, 18% нь Хүннүгээр, 8% нь Гэгээнтэнээр, 5% нь iCinema-аар, 4% нь Соёмбоор тус тус үйлчлүүлж байна.

Нийт үзвэрийн орлогын 43%-ийг Өргөө кино театр, 24%-ийг Тэнгис кино театр, 15%-ийг Хүннү кино театр, 10%-ийг Гэгээнтэн, 5%-ийг iCinema, 3%-ийг Соёмбо кино театр эзэмшиж байна.

Дээрх үр дүнгүүдээс харахад Өргөө кино театр зах зээлд бүхий л үзүүлэлтээр тэргүүлэх байх суурьтай байна. Өргөө 3 IMAX салбараа нээснээр үзэгчдийнхээ тоог 48%-иар, үзвэрийнхээ орлогыг 56%-иар нэмэгдүүлсэн байна.

Хэдийгээр сүүлийн 2 гаруй жилийн хугацаанд 5 кино театр шинээр нээгдсэн ч гэсэн Тэнгис кино театр хүчин чадлаа нэмэгдүүлэлгүй зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээр байна. Энэ нь түүний эрчимтэй үйл ажиллагаатай нь шууд холбоотой хэмээн дүгнэж байна.